



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/315

Улаанбаатар хот

Засгийн газрын үнэт цаас бүртгэх тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.3, "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 8 дугаар зүйлийн 8.10, 8.11, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалтууд, Сангийн сайдын 2026 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 129 дүгээр тушаалын хавсралт, Сангийн яамнаас ирүүлсэн 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн мэдэгдлийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй, купонтой, 2 жилийн хугацаатай, 50,000 (тавин мянга) ширхэг, нийт 5.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 1361 кодтой, ЗГЭБ-Д-104-539 нэртэй Засгийн газрын үнэт цаасыг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн үнэт цаасны бүртгэлд бүртгэсүгэй.

2. "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" хязгаарлагдмал хариуцлагатай компанид үнэт цаас хадгалуулах мэдэгдэл хүргүүлэхийг Хяналт, зохицуулалтын газар (А.Мөнхбаясгалан)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалаар бүртгэгдсэн Засгийн газрын үнэт цаасыг олон нийтэд арилжихтай холбоотой бэлтгэл ажлыг хангаж, арилжааг зохион байгуулахыг Үйл ажиллагааны газар (И.Жавхлан)-т үүрэг болгосугай.

4. Засгийн газрын үнэт цаас бүртгэгдэн, арилжихтай холбоотой мэдээллийг нийтэд хүргэх ажлыг Бизнес хөгжлийн газар (Т.Хаш-Эрдэнэ)-т, шимтгэлийг холбогдох журмын дагуу тооцон авахыг Захиргаа, санхүүгийн газар (Х.Эрдэнэбүрэн)-т тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын мэргэжилтэн Ч.Эрдэнэболорт даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.МӨНХБАТ

1526030641

Маягт 5

**ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН
ХАДГАЛАМЖИЙН ТӨВ ХХК-д
ХҮРГҮҮЛЭХ МЭДЭГДЭЛ №1361**

Хэнд: “Үнэт цаасны төвлөрсөн
хадгаламжийн төв” ХХК-д

Огноо: 2026/07/04

ҮЗҮҮЛЭЛТ	ҮНЭТ ЦААС БҮРТГҮҮЛЭХ
Мэдэгдлийн агуулга:	Үнэт цаас хадгалуулах тухай
Үндэслэл:	“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2026 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн №135 тоот тушаал
Санхүүгийн хэрэгсэл: /хувьцаа, өрийн хэрэгсэл гэх мэт/	Засгийн газрын үнэт цаас
Үнэт цаасны төрөл: /хямдруулалттай, купонтой/	Купонтой
Арилжааны хэлбэр: /ялгавартай үнэтэй, нэгдсэн үнэтэй/	Ялгавартай үнэтэй
Үнэт цаасны нэр:	ЗГЭБ-Д-104-539
Үнэт цаасны хэлбэр:/биет, биет бус/	Биет бус
Үнэт цаасны тоо:/ширхэг/	50,000 /тавин мянга/
Үнэт цаасны нэрлэсэн үнэ:/төгрөг/	100,000 /нэг зуун мянга/
Үнэт цаасны нийт үнийн дүн: /төгрөг/	5,000,000,000 /таван тэрбум/
Үнэт цаасны хугацаа: /долоо хоног, сар/	2 жил
Үнэт цаасны хүү төлөгдөх хугацаа: /давтамж/	2027.01.08, 2027.07.08 2028.01.08, 2028.07.08
Өрсөлдөөнт бус нийт саналд хуваарилах дээд хэмжээ: /%/	1,500,000,000 /нэг тэрбум таван зуун сая/
Нэг оролцогчид хуваарилах саналын хязгаар: /төгрөг/	25%
Үнэт цаас арилжих өдөр	2026.07.08
Үнэт цаасны хугацаа дуусах огноо	2028.07.08

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.МӨНХБАТ